



ЗАСАГ ДАРГА

БАТГАДАА

С.АМГАЛАН

2023 оны 04-р сарын 30-ны өдөр
9843881
0319292920

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023.04.30

Өвт

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, зөвлөмжийн агуулга	Зөвлөмжийн заалт	Хэрэгжүүлэх хугацаа /Улирал/	Хариуцах нэгж, албан тушаалтан	Өвт			
					1	2	3	4
Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт								
1.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг эзэнжүүлж, шаардлагатай шийдвэрт хувийн хэрэг нээж, хувийн хэргийн бүрдлийг ханган, баяжилт хийж ажиллах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.	Жилдээ	Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)				
2.	Өмнө нь гарсан шийдвэр, шийдвэрийн заалтыг нэг бүрчлэн шүүн үзэж хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтуудыг хяналтаас хасах, хэрэгжилт тогтмолжсон, байнгын шинжтэй шийдвэрүүдийг дотоод хяналтад авах	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.	Жилдээ	Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)				
3.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлagnаж байгаатай холбогдуулан хэрэгжилт удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа заалтуудын бодит үр дүнг нэмэгдүүлэх тал дээр санал, санаачилга гарган хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудтай уялдаатай ажиллаж гүйцэтгэлийг чанаржуулах, бодит үр дүнг нэмэгдүүлэх.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.	Жилдээ	Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн), Байгууллагын дарга эрхлэгч нар Албан хаагчид				
4.	Бодлогын баримт бичгийг тайлagnахдаа /Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр/ зорилтот түвшинг тодорхойлж, зөв, бодит үр дүнг тайлagnах	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.	1-р улиралд	Н.Орхонтуул (Засаг даргын орлогч) Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)				
5.	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хяналтад аваходаа сумандаа хэрэгжүүлж болох, үр дүн гарах арга хэмжээг хяналтад авч, жилийн эхнээс төлөвлөж хэрэгжүүлж ажиллах, хэрэгжилтийг батлагдсан журмын хавсралтын дагуу товч тодорхой тайлagnах, журмын дагуу иж бүрэн, тайлagnахад	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.	1-р улирлаас	Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)				

	анхаарч ажиллах нь зүйтэй.			
Хоёр. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт				
6.	Сумын Засаг даргатай байгуулсан гэрээний 6.1.10, 8.1.8 дахь арга хэмжээ нь тодорхой үр дүн гараагүй байх тул эрчимжүүлэх	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	2-р улиралд	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
7.	Зарим арга хэмжээний биелэлтийн хувьд үр дүнг товч тодорхой 2000 тэмдэгтэд багтаагаагүй буюу хэт нуршуу үйл явцыг нэг бүрчлэн дурдаж тайлагнасан.{9.4.1, 9.4.2)	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	Жилдээ	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга) Төсөвт байгууллагууд
8.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл. нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль болон уг хуулийг дагаж гарсан бусад эрх зүйн актад нийцүүлэн, албан хаагчдын саналыг тусган боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	3-р улиалд	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
9.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэгтийг тайлагнаадаа дунд хугацаанд болон тухайн жилд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн татаарх мэдээллийг үндсэн тайландаа тодорхой тусгаж тайлагнаадаа анхаарах шаардлагатай.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	4-р улиралд	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гурав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт				
10.	Засаг даргын Тамгын газар: -Зорилтын төлөвлөлт, тайлагналт хийгээгүй (зорилт бүрт арга хэмжээнүүдийн агуулгыг багтаасан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тавигдсан, түүнийхээ хэрэгжилтийг тайлагнаасан байх шаардлагыг анхаарах) -Төсвийн төлөвлөлт огт хийгдээгүй (төсвийн төлөвлөлтийг хийж, төлөвлөлтийн дагуу зарцуулалтыг тайлагнадаг байх) -Арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин харилцан уялдаагүй төлөвлөгдсөн. Жишээ нь: 6.5.4, 7.1.2, 9.1.5 гэх мэт Ерөнхий боловсролын сургууль -Шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшинг тодорхойлоходоо ойлгомжтой. хэмжигдэхүйц байх шаардлагыг хангах. (хэмжих нэгж тодорхой байх) -Үнэлгээ бодитой бус, ахиц өөрчлөлтийг бодитой дүгнэхэд анхаарах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4 Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	4-р улиралд 4-р улиралд	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга) Б.Ууганчимэг (ЕБСургуулийн захирал)

	<p>-Тайланг гаргахдаа гол үр дүн, үр нөлөөг тодорхойлсон байхад анхаарах</p> <p>Соёлын төв:</p> <ul style="list-style-type: none"> -Зорилтын төлөвлөлт, тайлагналт хийгээгүй (зорилт бүрт арга хэмжээнүүдийн агуулгыг багтаасан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тавигдсан, түүнийхээ хэрэгжилтийг тайлагнасан байх шаардлагын анхаарах) -Төсвийн төлөвлөлт хийгдээгүй. -Шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй. -Тайлагналтай харьцуулахад үнэлгээ бодитой бус дүгнэсэн. 			
11.	<p>Эрүүл мэндийн төв:</p> <ul style="list-style-type: none"> -Зорилтын төлөвлөлт, тайлагналт хийгээгүй (зорилт бүрд арга хэмжээнүүдийн агуулгыг багтаасан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тавигдсан, түүнийхээ хэрэгжилтийг тайлагнасан байх шаардлагыг анхаарах) -Төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг тайлагнахад анхаарах -Хэрэгжээгүй арга хэмжээний шалтгаан нөхцөлийг сайтар тодорхойлж, тухайн арга хэмжээнд үнэлгээг заавал өгсөн байх -Тайланг үйл явц бичих бус шалгуур үзүүлэлтийг зорилтот түвшинтэй харьцуулсан үр дүнгийн тайлан байхыг анхаарах. 	<p>Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4</p>	4-р улиралд	Соёлын төв Г.Баттулга
12.	<p><u>1, 2 дугаар цэцэрлэг</u></p> <p>-Тайлангийн тэргүү 1 дүгээр улирлын тайлан гэж бичигдсэн - Зорилтын төлөвлөлт, гүйцэтгэл байхгүй</p> <ul style="list-style-type: none"> -Хүснэгтэн тайландаа зурган тайлбар оруулах шаардлагагүй, Мэдээллийг илүү тодотгох зорилгоор харьцуулсан график, хүснэгтэн мэдээлэл ашиглаж болно.(зурган тайланг хавсралт файл болгон гаргаж болно.) -Үнэлгээ бодитой бус, үйл явц тайлагнахаас татгалзах, гол үр дүнгээ тайлагнадаг байх. 	<p>Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4</p>	4-р улиралд	Ж.Тогоохүү 2-р цэцэрлэгийн эрхлэгч, Н.Батжаргал 1-р цэцэрлэгийн эрхлэгч
13.	<p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа салбарын стратеги төлөвлөгөө бодлогын баримт бичгүүдтэй сайтар уялдуулж, арга хэмжээний санхүүжилт, шаардагдах хөрөнгийг бодитой төлөвлөх.</p>	<p>Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4</p>	4-р улиралд	Төсөвт байгууллагууд

14.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлагнахдаа гадаад хүчин зүйлээс шалтгаалж хэрэгжээгүй, эсвэл хэрэгжилт нь хойшилсон арга хэмжээг журмын дагуу заавал үнэлэх, хэрэгжээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой дурдах	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	4-р улиралд	Төсөвт байгууллагууд
15.	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж, хуваарилсан төсөл, хөтөлбөрүүдийн ихэнх нь үр дүнтэй хэрэгжсэн боловч эзарим хөрөнгийн чанар, ашиглалт, хадгалалт хангалтгүй, удирдлагын мэдээллийн систем, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ажлууд хангалтгүй.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	Хууль, журамд заасан хугацаанд	O.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч) Төсөвт байгууллагууд
16.	ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулга авахдаа иргэдийг тэгш хүртээмжгэй оролцуулж, саналын хуудсыг хүртээмжтэй байдлаар тарааж, иргэдийг идэвхжүүлэхэд санаачлагатай ажиллах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	Хууль, журамд заасан хугацаанд	O.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч) Багийн Засаг дарга нар
17.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын эрэмбэлсэн жагсаалтад иргэдийн өгсөн санал орсон эсэхийг иргэдэд бүрэн мэдээлж ажиллахад анхаарах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	Хууль, журамд заасан хугацаанд	Ажлын хэсэг
18.	Аймгийн Төсвийн өрөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын хорооны 2022 оны "Дотоод аудит, хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ" 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах. (тогтоолын 4, 5, 8 дугаар заалт)	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4	Жилдээ	O.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Дөрөв. Байгууллагын нээлттэй байдал				
19.	Байгууллагын цахим сайт, мэдээллийн самбарыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нээлттэй мэдээлэхээр заасан мэдээллийн жагсаалтын дагуу хөтлөх, шинэчлэх ажлыг албан хаагчдад хариуцуулж, хяналт тавьж ажиллах, мэдээллийн шинэчлэлтийн хугацаа, мэдээ, мэдээллийн агуулга, алдааг хянаж засварлахад анхаарч ажиллах шаардлагатай.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5	Жилдээ	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга) Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)
20.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1- д заасан мэдээлэл хариуцагч гэж Төрийн байгууллага 8 дугаар эүйлийн 8.2 дахь заалтад Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5	Жилдээ	Төсөвт байгууллагууд

	байлгана гэж заасны дагуу бүх төсөвт байгууллагууд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.			
Тав. Шударга байдлын түвшний үнэлгээ:				
21.	Цахим сайтдаа авлигын чиглэлээрх мэдээллээ шинэчлээгүй, үүсгэсэн цэсний нэр болон байршуулсан мэдээлэл зөрүүтэй, ач холбогдолгүй, хамааралгүй мэдээлэл байршуулсан, цэс үүсгэж мэдээлэл байршуулсан боловч Авлигатай тэмцэх газрын болон шилэн данс. холбогдох яамны сайтыг шууд холбосон зэрэг зөрчил, мэдээллийн шинэчлэл, баяжилт хангалтгүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байна.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5	Жилдээ	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
22.	Авлигын чиглэлээр өдөр тутмын хийсэн ажлуудаа тогтмол оруулах, сумдын Засаг даргаас төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч нартай байгуулах гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр, мөн авлигын эсрэг хуулийн үйпчлэлд хамаарах этгээдэд сургалтын менежер, нягтлан бодогч нарыг хамруулан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулдаг болсон тул энэ чиглэлээр тодорхой заалт тусган цэцэрлэг, сургуулийн удирдлагуудтай дээрх албан тушаалтнууд өөрчлөгдхөх, солигдох, ажлаас чөлөөлөгдхөх тухай бүр сумын Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэн, ХАСУМ хянуулах, томилогдонон дараа 30 хоногт ХАСХОМ гаргах чиглэлээр тодорхой заалт тусган, үр дүнг тооцож ажиллах нь зүйтэй байна.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5	Хууль, журамд заасан хугацаанд	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
Зургаа. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:				
23.	Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж, тогтоосон хугацаанд нь холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг байнга хангаж ажиллах	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5	Хууль, журамд заасан хугацаанд	О.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч) Төсөвт байгууллагууд
Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт:				
24.	Төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын хүрээнд судалгаа, мэдээллийн сантай байх	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5	Жилдээ	Бүх төрийн албан хаагч

25.	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам боловсруулж мөрдөх, хуралдааны тэмдэглэл, зөвлөмж, илтгэх хуудас, удирдамж гэх мэт баримт бичгийг стандартын шаардлагад нийцүүлэх, байгууллагын архивт албан хаагчдаас баримтыг бүрэн бүрдэлтэй, хугацаанд нь шилжүүлэн авч хэвших.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5	1-р улиралд	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
26.	цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тодорхой төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5	2, 3-р улиралд	Архив, бичиг хэргийн эрхлэгч
27.	Хариутай албан бичигт хяналтын карт хөтлөгдөхгүй байна. Албан бичиг болон өргөдөл, гомдолын шийдвэрлэлтийн хөтлөлтийг бүртгэлийн дэвтэр болон хяналтын картанд тодорхой тусгаж, эргэн мэдэгдсэн байдал тодорхой байх асуудалд анхаарах	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5	1-р сард	Архив, бичиг хэргийн эрхлэгч
Найм. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой тесел, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлт				
28.	"Тэрбум мод" хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа суурь түвшингээ тодорхойлоогүй эсвэл буруу тодорхойлсон. хүрэх түвшинг тодорхойлоогүй учраас хийсэн ажлыг үнэлсэн байдал бодит бус, үр дүнг хүрэх түвшинтэйгээ харьцуулж шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй нийтлэг алдаа дутагдал байна.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 6	4-р улиалд	Б.Янжиндулам (БОХУБ)
29.	Мод тарих газрыг газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөндөө тусгах. тарьсан модны усалгаа, арчилгааг хэрхэн шийдэж авч явах тал дээр онцгой анхаарч жил бүр тарьсан модны тооллого зохион байгуулж амьдралтын хувийг үнэн зөв тодорхойлж байх.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 6	Жил бүр	Б.Янжиндулам (БОХУБ) Сум дундын Ойн анги
30.	Төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх E-Mongolia системд нэвтрүүлсэн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зохион байгуулалтын арга хэмжээ авч идэвх санаачлагатай ажиллах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 6	Жилдээ	Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга) Сумын Оператор хариуцсан мэргэжилтэн
31.	"Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем егр e-mongolia.mn-ийг нэвтрүүлэх. ашиглалтыг эрчимжүүлэх	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 6		Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга) Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн) Архив, бичиг хэргийн эрхлэгч

32.	Сумын төсөвт болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд эх үүсвэр дээр нь ангилан ялгах савыг нэг бүрчлэн байршуулах, ангилсан дахивар хог хаягдлыг аймаг, орон нутгийн дахивар хүлээн авах цэгүүдэд хүргэх горимыг тодорхой болгож тухайн үйл ажиллагааг тогтмолжуулах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 6	2, 3-р улиралд	Н.Орхонтуул (Засаг даргын орлогч) Б.Янжиндулам (БОХУБ) Бат-Өлзий-тохижилт, үйлчилгээний УҮГазар
33.	Төвлөрсөн хогийн цэг дээр байгуулсан аюултай хог хаягдлыг устгах цэгт аюултай хог хаягдлыг Засгийн гээрын 2018 оны 116 дугаар тогтоолоор батлагдсан "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам"-ын дагуу устгаж хэвших.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 6	Тухай бүр	Н.Орхонтуул (Засаг даргын орлогч) Б.Янжиндулам (БОХУБ) Бат-Өлзий-тохижилт, үйлчилгээний УҮГазар
34.	Иргэд, хүүхэд багачуудад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, иргэдийн зөв дадал хэвшилтэй холбоотой сургалт. Нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 6	4, 9 дүгээр саруудад	Б.Янжиндулам (БОХУБ) Бат-Өлзий-тохижилт, үйлчилгээний УҮГазар, ЕБС, СӨББ-ын удирдлагууд

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД